



“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.БАЛДОРЖ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 15 № 3/441
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

3,542.6 сая төгрөгийн хойшлогдсон орлогыг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд байгуулсан 682.2 сая төгрөгийн элэгдлийн хэмжээгээр бууруулж тухайн тайлант үеүдэд орлогоор бүртгэж тайлагнаагүй, 194.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу явуулаагүй, худалдан авалтыг гэрээний дагуу хийгээгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 69.6 сая төгрөгөөр дутуу тооцож бүртгэж тайлагнасан, 64.0 сая төгрөгийн нэмэлт ажил үйлчилгээний орлогыг төлбөрийн тооцоо

хийгдээгүй байхад хуваарилж авлагаар бүртгэсэн, татварын өр, авлагыг буруу бүртгэсэн, байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй 10.7 сая төгрөгийн зардал гаргасан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В.М

Ц.НАРАНЧИМЭГ

2017.10.22



“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Санхүүгийн Аудитын Газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512
Цахим хаяг: batsaikhann@audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дугаар заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 01-наас 2017 оны 03 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн Энур Аудит ХХК-ийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК нь 2016 оны санхүүгийн тайлангаа 2017 оны 2 дугаар сарын 13-нд 1/183 тоот албан бичгээр Энур Аудит ХХК-т ирүүлсэн байна.

Энур Аудит ХХК аудитыг 2016 оны 10 дугаар сарын 01-нээс 2017 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн захирал нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, “Компанийн тухай”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэгдэн мөрдөгдсөн Сангийн сайдын журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК нь 2001 оны 2-р сард УИХ-р батлагдсан “Эрчим хүчний тухай” хууль, МУ-н Засгийн газрын мөн оны 164 тоот тогтоолын дагуу 2001 оны 8-р сарын 1-ний өдрөөс “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бие даан үйл ажиллагаа явуулж байна.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК нь Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний найдвартай, тогтвортой ажиллагааг хангасан, эдийн засгийн хэмнэлттэй, оновчтой горимыг тооцон мөрдүүлж, хэрэглэгчдийн стандартын шаардлагад нийцсэн цахилгаан, дулаанаар хангах үйл явцыг хоногийн 24 цагийн турш тасралтгүй хянаж зохицуулах, цахилгаан, дулааны үйлдвэрлэлт, хэрэглээний тэнцвэржилтийг хангах үндсэн зорилготой.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэх захирлыг “Компанийн тухай” хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8-д Төлөөлөн удирдах зөвлөл нь “компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилж, гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний дагуу компанийн үйл ажиллагааг удирдаж байна.

ТӨХХК-ийн гүйцэтгэх захиралтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд компанийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 25 дугаар тогтоолоор “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц орон тоог шинэчлэн баталсан байна.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар, нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт” болон “Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах норм тогтоох” зэрэг заавар журмын өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулахаар “Интер аудит” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Интерактив Би Ай” ХХК-ийн Даймонд санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

Гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-1 маягтыг ашиглан материаллаг байдлын түвшинг тогтоохдоо нийт хөрөнгийг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт орлого, нийт зардлаас тооцоход хэтэрхий их байгаа тул нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс шинэчлэн тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 1 хувиар буюу 450.1 сая төгрөгөөр тооцов.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Эрчим хүчний тухай хуулийн дагуу “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК нь 2016 оноос эхлэн салбарын "Нэг худалдан авагч"-ийн загварыг хариуцан ажиллаж эхэлснээр санхүүгийн үйл ажиллагаа нь 2 үндсэн хэсгээс бүрдэж, тэдгээрийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан байна. Үүнд:

(1) Эрчим хүчний яам, салбарын үнэ тарифын асуудлыг хариуцсан Эрчим хүчний зохицуулах хороогоор батлуулсан зардлын тарифын хүрээнд диспетчерийн зохицуулалтын үйл ажиллагааны орлого, зардал, их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээг хөтөлж, тайлагнах,

(2) Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын төлбөрийн мөнгөн урсгал, эрчим хүчний импорт, экспортын төлбөрийг "Нэг худалдан авагч"-ийн загвараар хөтөлж, байгууллагуудын авлага, өр төлбөрийн тооцоо, төсөвт төлөх татвар, ашиг, алдагдлын тооцоог нэгтгэн тайлагнах үйл ажиллагаа хамаарч байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 199 дүгээр тогтоолыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийж нийт 4,683.8 сая төгрөгийн орлого олж, 4,683.8 сая төгрөгийн зардал гаргаж ажиллахаар баталсан байна.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК нь тайлант онд диспетчерийн зохицуулалтын 4,683.8 сая төгрөгийн, цахилгаан дамжуулалтын 455,681.5 сая төгрөгийн нийт 460,365.2 сая төгрөгийн орлого олж, нийт 456,479.9 сая төгрөгийн зардал гаргаж, 546.0 сая төгрөгийн орлогын татварын зардал тооцож, 3,339.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үүнээс диспетчерийн зохицуулалтын 4,683.8 сая төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

ТӨБЗГазрын 2016 оны 10 сарын 20-ны өдрийн 101 тоот тогтоолын дагуу 2015 оны ногдол ашиг болох 7.1 сая төгрөгийг сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих

мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар судлаж үзэхэд www.shilendans.gov.mn сайтад хуульд заасан мэдээллийг байршуулсан ба зорилтот түвшиний төлөвлөгөө гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалтын мэдээллийг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 26 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 36 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага өглөг, үйл ажиллагааны орлого, зардлын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 81.4 хувь, мөнгөн хөрөнгийн 79.6 хувь, урьдчилж төлсөн тооцооны 56.8 хувь, нийт зардлын 50 хувь, нийт бараа материалын 69.0 хувь, үндсэн хөрөнгийн 64.1 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 3,542.6 сая.төгрөгийн хойшлогдсон орлогыг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд байгуулсан 682.2 сая төгрөгийн элэгдлийн хэмжээгээр бууруулж тухайн тайлант үеүдэд орлогоор бүртгэж тайлагнаагүй байгаа нь НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлогоор бүртгэж, тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэй сууриар ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө” –той нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар хойшлогдсон орлогоор бүртгэсэн хөрөнгийг НББОУС 20-ын дагуу тайлант үеийн элэгдлийн зардлын хэмжээгээр орлогоор бүртгэж хойшлогдсон орлогыг системтэйгээр бууруулж бүртгэж тайлагнах талаар, буцалтгүй тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ТӨХБЗГазраар тухай бүр шийдвэр гаргуулж эх үүсвэрийг бүртгэж байх талаар аудитын зөвлөмж хүргүүлэв.

2. **ТШ-2016-19** шуурхай үйлчилгээнд ашиглагдах автомашин 60.0 сая төгрөгийн өртөгтэй нээлттэй тендер, **ТШ-2016-20** Сэлэнгэ-Сүхбаатар-Буриад РДУ-ын хооронд тоон суваг үүсгэх төгсгөлийн төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах 134.0 сая төгрөгийн өртөгтэй нээлттэй тендерийн үйл ажиллагааг явуулахдаа e-procurement.mn сайт болон өдөр тутмын сонинд зар нийтлээгүй, тендерийн үр дүнг e-procurement.mn сайтад мэдээлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21.1 “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” 21.4 “Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байршуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ” заалттай тус тус нийцэхгүй байна.
- Мөн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хараат бус гишүүн оруулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4 “худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан 301 нэр төрлийн 433.7 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгээгүй байгаа нь НББОУС 16 хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, шийдвэр гаргуулж үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Нэгтгэсэн санхүүгийн тайланд Диспетчерийн үндэсний төв болон арилжаа зохицуулалтын албаны нэг худалдан авагчийн санхүүгийн тайлан дахь 1,801.8 сая төгрөгийн авлага, өглөгийг цэвэрлэж тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Нэгтгэсэн санхүүгийн тайланг залруулж авлага, өглөгийг цэвэрлэж тайлагнасан болно.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Биет үндсэн хөрөнгийн элэгдэл болон биет бус хөрөнгийн хорогдуулалтыг 69.6 сая төгрөгөөр дутуу тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж “ тус хуулийн 4.1.1-д зааснаар санхүүгийн тайланг гаргахдаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 4.1.1-д заалтыг дагаж мөрдөх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. 2016 оны 12-р сарын 31-ны байдлаар нэмэлт ажил үйлчилгээний төлбөрийн 64.0 сая төгрөгийн авлагатай байгаа нь “нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ын 5.3 “Ажил үйлчилгээний төлбөр компанийн харилцах данс болон бэлэн мөнгөний касст бүрэн орсон нөхцөлд цэвэр ашгийн 60 хувийг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн ажиллагсдын урамшуулалд оролцоогоор нь олгох, үлдсэн 40 хувийг компанийн ашигт тооцон ажиллагсдын нийгэм соёлын арга хэмжээнд тус тус зарцуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: “Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ын 5.3 заалтыг хэрэгжүүлж ажиллах, нэмэлт ажил үйлчилгээний орлого байгууллагын дансанд бүрэн ороогоогүй байхад хуваарилсан орлогыг ажиллагсдаас буцааж суутгах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Смарт Крафт ХХК-тай “ДЦС-4 ТӨХК-ийн 7-р генераторыг СКАДА системд холбох ажил”-ын тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах, туршилт тохируулга хийхээр 27.0 сая төгрөгийн гэрээ хийж гэрээний дагуу урьдчилгаа төлбөр 10.9 сая төгрөгийг, 03 дугаар сарын 23-нд ажил хүлээлцсэн акт үйлдэж, 2016 оны 04 дүгээр сарын 04-нд гэрээ дүгнэж үлдэгдэл төлбөр 15.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч дээрх тооцоог хааж нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.

Экспертлинк ХХК-тай Дархан-Селендумын 220 кв-ын 257,258-р ЦДАШ-аар шилэн кабель суурилуулах, ОХУ-ын Буриадын эрчим хүчний системийн РДУ болон ДҮТ ХХК-ийн хооронд тоон суваг үүсгэх ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба гэрээт ажил дуусаагүй, гэрээт ажлыг хүлээлцээгүй байхад үлдэгдэл төлбөр болох 38.5 сая төгрөгийг олгосон нь гэрээний тусгай нөхцөлийн 48 “...Эцсийн төлбөр болох гэрээний үнийн дүнгийн 45 хувь буюу 43 652 043 төгрөгийг ажлын хөтөлбөрт заасан ажлыг гүйцэтгэж дууссаны дараа ажил хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн санхүүжүүлнэ “нь гэрээний тусгай нөхцөлийн 54 “Эцсийн санхүүжилтийг объектийг ашиглалтанд хүлээн авсан комиссын акт гарснаас хойш ажлын 14 хоногийн дотор санхүүжүүлнэ “ заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Авлагыг барагдуулах, гэрээт ажлыг дуусгах талаар арга хэмжээ авч ажиллах, гэрээт ажлын төлбөрийг гэрээний дагуу санхүүжүүлж хэвших талаар удирдлагад албан шаардлага хүргүүлэв.

4. НДШ, ХХОАТ, НӨАТ, ААНОАТ-ын тайлангаарх өр төлбөрийн эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн өр төлбөрийн үлдэгдлээс зөрүүтэй. Татварын өрийг барагдуулаагүй, тайлант хугацааны НДШ, ХХОАТ, НӨАТ, ААНОАТ-ын тайлангийн ногдуулалт санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 хэсэгт “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Албан татвар төлөгч нь нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн заалт болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1 дүгээр зүйл, 21.4-т заасныг мөрдөн ажиллах, татварын өрийг хуулийн хугацаанд барагдуулж хэвших талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

5. Шинэ жилийн арга хэмжээнд 19.6 сая төгрөг зарцуулсан, Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн тушаалын дагуу ЭХЗХороо байгуулагдсаны 15 жилийн ойд зориулж 2.0 сая төгрөгийн, Налайхын ДС байгуулагдсаны 40 жилийн ойд зориулж 0.2 сая төгрөгийн хандивын зардал гаргасан нь төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх, хандивын зардал гаргахгүй байх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

6. Компанийн үйл ажиллагаатай холбоогүй нийт 10.7 сая төгрөгийг зарцуулж урьдчилж гарсан зардал болон зардлын дансанд бүртгэсэн

Шийдвэрлэсэн: Компанийн үйл ажиллагаатай холбоогүй зардал болох 10.7 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангаар 3,542.6 сая.төгрөгийн хойшлогдсон орлогоор бүртгэсэн хөрөнгийн тайлант онд байгуулсан 682.2 сая төгрөгийн элэгдлийн зардлын хэмжээгээр хойшлогдсон орлогыг бууруулж бүртгээгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2013-2015 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн тайлан, хөндлөнгийн мэдээллийг үндэслэн Хан-Уул дүүргийн татварын хэлтсээс шалгалтыг хийж 767.3 сая төгрөгийн нөхөн татвар, 281.0 сая төгрөгийн торгууль, 2.1 сая төгрөгийн хүү, нийт 1,050.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон нь татварын эрсдэлтэй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар ДҮТ болон Арилжаа зохицуулалтын албаны хоорондын тооцоо болох 2050 тоот харилцагчийн гүйлгээг болон НДШ, ХХОАТ, НӨАТ, ААНОАТ-ын тайланг буруу тайлагнасан татварын өглөг, авлагын үлдэгдэл зөрүүтэй татварын эрсдэл өндөр байгаа тул татварын тайлагналын талаар авч үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,221.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс аудитын явцад 1,819.0 сая төгрөгийн алдааг залруулан бүртгэж, 2,326.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 64.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 10.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар менежментийн захидлаар 4 зөвлөмж хүргүүлсэнээс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг СТОУС-ын дагуу тооцож бүртгэх, ААНОАТ, ХХОАТ, НӨАТ-ыг үнэв зөв тооцоолж бүртгэх гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсан шалтгааныг тодруулахад байгууллагын зорилтот түвшиний төлөвлөгөөнд Эрчим хүчний зохицуулах хорооноос элэгдлийн зардлын хэмжээг тогтоож өгдөг тул элэгдлийн зардлыг бүрэн байгуулах боломжгүй гэсэн тайлбар өгсөн. Харин ААНОАТ, ХХОАТ, НӨАТ-ыг үнэв зөв тооцоолж бүртгэх талаар өгсөн зөвлөмжийг огт хэрэгжүүлээгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

3,542.6 сая.төгрөгийн хойшлогдсон орлогыг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд байгуулсан 682.2 сая төгрөгийн элэгдлийн хэмжээгээр бууруулж тухайн тайлант үеүдэд орлогоор бүртгэж тайлагнаагүй, 194.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу явуулаагүй, худалдан авалтыг гэрээний дагуу хийгээгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 69.6 сая төгрөгөөр дутуу тооцож бүртгэж тайлагнасан, 64.0 сая төгрөгийн нэмэлт ажил үйлчилгээний орлогыг

төлбөрийн тооцоо хийгдээгүй байхад хуваарилаж авлагаар бүртгэсэн, татварын өр, авлагыг буруу бүртгэсэн, байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй 10.7 сая төгрөгийн зардал гаргасан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлийг эс тооцвол “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд тус тус хавсаргав.



“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Хойшлогдсон орлогын талаар

Асуудал 2
Худалдан авах ажиллагааны талаар

Асуудал 3
Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Нэмэлт ажил үйлчилгээний авлагын талаар

Асуудал 2
Татварын тооцоолол, татварын өр, авлагын талаар

Асуудал 3
Хандив болон шинэ жилийн арга хэмжээний
зардлын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Төрийн Аудитын Байгууллагын аудитын горимд үндэслэсэн болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Хойшлогдсон орлогын талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

3,542.6 сая.төгрөгийн хойшлогдсон орлогыг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд байгуулсан 682.2 сая төгрөгийн элэгдлийн хэмжээгээр бууруулж тухайн тайлант үеүдэд орлогоор бүртгэж тайлагнаагүй байгаа нь НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлогоор бүртгэж, тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэй сууриар ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө “ –той нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Хойшлогдсон орлогоор бүртгэсэн хөрөнгийг НББОУС 20-ын дагуу тайлант үеийн элэгдлийн зардлын хэмжээгээр орлогоор бүртгэж хойшлогдсон орлогыг системтэйгээр бууруулж бүртгэж тайлагнах, буцалтгүй тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ТӨХБЗГазраар тухай бүр шийдвэр гаргуулж эх үүсвэрийг бүртгэж байх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,
Ашиг алдагдал буруу илэрхийлэгдэх,
татварын эрсдэл үүсэх,
Удирдлагад буруу мэдээлэл хүрэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Худалдан авах ажиллагааны талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

ТШ-2016-19 шуурхай үйлчилгээнд ашиглагдах автомашин 60.0 сая төгрөгийн өртөгтэй нээлттэй тендер, ТШ-2016-20 Сэлэнгэ-Сүхбаатар-Буриад РДУ-ын хооронд тоон суваг үүсгэх төгсгөлийн төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах 134.0 сая төгрөгийн өртөгтэй нээлттэй тендерийн үйл ажиллагааг явуулахдаа e-procurement.mn сайт болон өдөр тутмын сонинд зар нийтлээгүй, тендерийн үр дүнг e-procurement.mn сайтад мэдээлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21.1 “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээнэ” 21.4 “Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байршуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээнэ” заалттай тус тус нийцэхгүй байна.

Мөн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хараат бус гишүүн оруулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4 “худалдан авах ажиллагааны илтөд байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтаныг оролцуулна” заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх,

Хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө бэлтгэсэн, бүртгэж тайлагнасан байх,

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Үндсэн хөрөнгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан 301 нэр төрлийн 433.7 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгээгүй байгаа нь НББОУС 16 хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” заалттай нийцэхгүй байна.

Биет үндсэн хөрөнгийн элэгдэл болон биет бус хөрөнгийн хорогдуулалтыг 69.6 сая төгрөгөөр дутуу тооцсон нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж “ тус хуулийн 4.1.1-д зааснаар санхүүгийн тайланг гаргахдаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө заалттай нийцэхгүй байна

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан болон тайлант хугацааны ашиг алдагдал буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн, шийдвэр гаргуулж үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг дахин тогтоож, үнэлж бүртгэх.

НББОУС 16-д “ хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүнийг ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилна, Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу өөрөөр хэлбэл, түүнийг удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангасан үеэс эхлэн элэгдэл тооцно” заалтыг дагаж мөрдөх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Нэмэлт ажил үйлчилгээний авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны 12-р сарын 31-ны байдлаар нэмэлт ажил үйлчилгээний төлбөрийн 64.0 сая төгрөгийн авлагатай байгаа нь “нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ын 5.3 “Ажил үйлчилгээний төлбөр компанийн харилцах данс болон бэлэн мөнгөний касс бүрэн орсон нөхцөлд цэвэр ашгийн 60 хувийг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн ажиллагсдын урамшуулалд оролцоогоор нь олгох, үлдсэн 40 хувийг компанийн ашигт тооцон ажиллагсдын нийгэм соёлын арга хэмжээнд тус тус зарцуулна” заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

“Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ын 5.3 заалтыг хэрэгжүүлж ажиллах, нэмэлт ажил үйлчилгээний орлого байгууллагын дансанд бүрэн ороогоогүй байхад хуваарилсан орлогыг ажиллагсдаас буцааж суутгах.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан болон тайлант хугацааны ашиг алдагдал буруу илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Татварын тооцоолол, татварын өр, авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

НДШ, ХХОАТ, НӨАТ, ААНОАТатварын тайлангаарх өр төлбөрийн эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн өр төлбөрийн үлдэгдлээс зөрүүтэй. Татварын өрийг барагдуулаагүй, тайлант хугацааны НДШ, ХХОАТ, НӨАТ, ААНОАТатварын тайлангийн ногдуулалт санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 хэсэгт “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Албан татвар төлөгч нь нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн заалт болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1 дүгээр зүйлд заасныг мөрдөн ажиллах, татварын өрийг хуулийн хугацаанд барагдуулж хэвших.

Эрсдэлүүд

Санхүү байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайлан буруу илэрхийлэгдэх
Холбогдох хууль, дүрэм, журам зөрчигдөх
ААНОАТ-ын тухай, НӨАТ-ын тухай, ХХОАТ-ын тухай, Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Хандив болон шинэ жилийн арга хэмжээний зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Шинэ жилийн арга хэмжээнд 19.6 сая төгрөг зарцуулсан.

Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн тушаалын дагуу ЭХЗХороо байгуулагдсаны 15 жилийн ойд зориулж 2.0 сая төгрөгийн, Налайхын ДС байгуулагдсаны 40 жилийн ойд зориулж 0.2 сая төгрөгийн хандивын зардал гаргасан нь төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 ” Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх.

Хандивын зардал гаргахгүй байх.

Эрсдэлүүд

Хууль, тогтоомж зөрчигдөх

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Балансын зүйл	Аудит хийхийн өмнөх үлдэгдэл		Залруулга	Аудитлагдсан үлдэгдэл
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
ХӨРӨНГӨ				
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ				
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	296,457,088.06	3,226,981,909.87		3,226,981,909.87
Дансны авлага	201,444,762.74	26,511,559,439.81	(1,801,841,153.35)	24,709,718,286.46
Татвар, НДШ-ийн авлага	458,004.11	774,275,347.54		774,275,347.54
Бусад авлага	-	1,041,776,451.31		1,041,776,451.31
Бараа материал	236,986,756.70	284,070,408.63		284,070,408.63
Урьдчилж төлсөн зардал тооцоо	137,660,523.00	188,276,645.00		188,276,645.00
Бусад эргэлтийн хөрөнгө	-	75,628,309.33		75,628,309.33
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	873,007,134.61	32,102,568,511.49	(1,801,841,153.35)	30,300,727,358.14
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ				
Үндсэн хөрөнгө	9,866,286,325.68	8,878,702,316.90		8,878,702,316.90
Биет бус хөрөнгө	4,145,134,222.87	4,031,107,902.98		4,031,107,902.98
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,011,420,548.55	12,909,810,219.88	-	12,909,810,219.88
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,884,427,683.16	45,012,378,731.37	(1,801,841,153.35)	43,210,537,578.02
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Дансны өглөг	84,615,309.57	19,271,509,284.78	(1,801,843,153.35)	17,469,666,131.43
Татварын өр	45,598,998.98	1,007,100,607.19	7,720,436.36	1,014,821,043.55
НДШ-ийн өглөг	946,060.53	946,060.53		946,060.53
Урьдчилж орсон орлого	3,495,940,297.07	3,477,989,465.32		3,477,989,465.32
Бусад богино хугацаат өр төлбөр	-	3,228,196,131.11		3,228,196,131.11
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	3,627,100,666.15	26,985,741,548.93	(1,794,122,716.99)	25,191,618,831.94
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Урт хугацаат зээл	9,800,801,781.86	9,499,281,708.79		9,499,281,708.79
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	9,800,801,781.86	9,499,281,708.79	-	9,499,281,708.79
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	13,427,902,448.01	36,485,023,257.72	(1,794,122,716.99)	34,690,900,540.73
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч: - төрийн	1,842,324,959.90	1,842,324,959.90		1,842,324,959.90
Нэмж төлөгдсөн капитал	-	3,406,082.55		3,406,082.55
Эздийн өмчийн бусад хэсэг		3,711,108,558.61	16,323,179.38	3,727,431,737.99
Хуримтлагдсан ашиг	(385,799,724.75)	2,970,515,872.59	(24,041,615.74)	2,946,474,256.85
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,456,525,235.15	8,527,355,473.65	(7,718,436.36)	8,519,637,037.29
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,884,427,683.16	45,012,378,731.37	(1,801,841,153.35)	43,210,537,578.02

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он		
		Аудит хийхийн өмнөх тайлан	Залруулга	Аудитлагдсан тайлан
Борлуулалтын орлого /цэвэр/	3,261,987,400.00	460,365,234,242.78		460,365,234,242.78
Борлуулалтын өртөг	2,508,355,533.81	449,758,742,877.75		449,758,742,877.75
Нийт ашиг (алдагдал)	753,631,866.19	10,606,491,365.03		10,606,491,365.03
Хүүгийн орлого	8,980,621.42	102,838,554.76		102,838,554.76
Бусад орлого	83,298,046.96	268,446,789.10		268,446,789.10
Борлуулалт, маркетингийн зардал	-	1,842,730.51		1,842,730.51
Ерөнхий ба удирдлагын зардал	756,475,298.58	2,123,338,879.84		2,123,338,879.84
Бусад зардал	64,453,256.63	4,864,577,409.60		4,864,577,409.60
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,132,205.55	(102,655,099.83)		(102,655,099.83)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	26,114,184.91	3,885,362,589.11	-	3,885,362,589.11
Орлогын татварын зардал	2,605,737.94	529,857,550.89	16,178,536.62	546,036,087.51
Татварын дараах ашиг (алдагдал)	23,508,446.97	3,355,505,038.22	(16,178,536.62)	3,339,326,501.60
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-	-	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	23,508,446.97	3,355,505,038.22	(16,178,536.62)	3,339,326,501.60
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		
Орлогын нийт дүн	23,508,446.97	3,355,505,038.22	(16,178,536.62)	3,339,326,501.60

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,842,324,959.90	-	-	(1,299,949,810.87)	542,375,149.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	890,641,639.15	890,641,639.15
Залруулсан үлдэгдэл	1,842,324,959.90			(409,308,171.72)	1,433,016,788.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		-	23,508,446.97	23,508,446.97
Бусад дэлгэрэнгүй орлого	-		-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-		-	-	-
Зарласан ногдол ашиг	-		-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-	-	-
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,842,324,959.90	-	-	(385,799,724.75)	1,456,525,235.15
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		3,727,431,737.99	3,339,326,501.60	7,066,758,239.59
Бусад дэлгэрэнгүй орлого	-		-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	3,406,082.55	-	-	3,406,082.55
Зарласан ногдол ашиг	-		-	(7,052,520.00)	(7,052,520.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-	-	-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,842,324,959.90	3,406,082.55	3,727,431,737.99	2,946,474,256.85	8,519,637,037.29

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	3,282,825,719.05	515,740,405,975.77
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,212,247,050.67	515,739,956,574.77
Бусад мөнгөн орлого	70,578,668.38	449,401.00
Мөнгөн зарлагын дүн (-)	2,551,273,972.60	512,721,085,149.08
Ажиллагчдад төлсөн	1,220,353,112.00	1,284,158,392.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	317,875,233.03	98,640,494.42
Бараа материал худалдан авахад төлсөн	77,736,028.00	505,616,331,701.56
Ашиглалтын зардалд төлсөн	44,972,026.00	39,395,660.60
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,489,149.00	28,767,065.59
Хүүний төлбөрт төлсөн	133,403,196.00	63,733,478.87
Татварын байгууллагад төлсөн	177,228,338.75	5,404,848,311.89
Даатгалын төлбөрт төлсөн	15,454,057.00	19,431,012.00
Бусад мөнгөн зарлага	545,762,832.82	165,779,032.15
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	731,551,746.45	3,019,320,826.69
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Хүлээн авсан хүүгийн орлого	8,980,621.42	102,838,554.76
Мөнгөн зарлагын дүн (-)	352,423,082.35	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	352,423,082.35	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(343,442,460.93)	102,838,554.76
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	57,802.68	116,938,033.43
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	57,802.68	116,938,033.43
Мөнгөн зарлагын дүн (-)	301,521,070.00	308,572,593.07
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	301,520,073.14	301,520,073.07
Төлсөн ногдол ашиг	-	7,052,520.00
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	996.86	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(301,463,267.32)	(191,634,559.64)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	86,646,018.20	2,930,524,821.81
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	209,811,069.86	296,457,088.06
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	296,457,088.06	3,226,981,909.87